

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулсан
дүрэм журам батлах тухай

“Үнэт цаасны зах зээлийн тухай” болон “Компанийн тухай”, “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай” хуулиудын холбогдох заалтыг үндэслэн Үнэт цаасны хорооноос тогтоох нь:

НЭГ. Холбогдох хуулиудад нийцүүлэн шинээр буюу нэмэлт, өөрчлөлт оруулсан хавсралтад дурьдсан дараахь дүрэм, журмуудыг баталсугай. Үүнд:

1. ~~Үнэт цаасны хорооны дүрэм~~
/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 74 дүгээр тогтоолоор хүчингүй/
2. Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн дүрэм
3. Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам
4. Санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулгад тусгагдах үзүүлэлт, тайлан, мэдээний маягт хэрэглэх журам
5. ~~Үнэт цаас өмчлөгчийн мэдэгдэл хүлээн авах, бүртгэх тухай журам~~
/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор хүчингүй/
6. Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчийн үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам

ХОЁР. Дүрэм, журмуудыг шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулан баталсантай холбогдуулан дараахь журмуудыг хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1. 1995.05.07-ны өдрийн 20 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн дүрэм”, 1996.7.25-ны өдрийн 62 дугаар тогтоолоор баталсан “Улсын байцаагчийн үйл ажиллагааны үр дүнг тооцох тухай заавар”
2. 1995.03.30-ны өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам ”
3. 1995.11.23-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “ХК-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны хагас жилийн тайлан тэнцлийн хураангуйг нэгтгэх заавар”
4. ХК-ийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх чанарын үзүүлэлтийг тодорхойлох журам
5. 2002.04.04-ны өдрийн 11 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас өмчлөгчийн мэдэгдэл хүлээн авах, бүртгэх тухай журам”
6. 1997.10.19-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагааны тухай журам”
7. 1997.03.06-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1,2 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны дотоод мэдээллийн жагсаалт” болон “Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигчийн жагсаалт”

8. 1995.06.22-ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагч аж ахуйн нэгжийн болон үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх тухай журам”

9. 1996.08.15 ны өдрийн 72 дугаар тогтоолоор батлагдсан “Хорооны гишүүд, ажилтнууд үнэт цаас өмчилж байгаагаа Хороонд мэдээлэх тухай журам”

ГУРАВ. Шинээр баталсан дүрэм, журмуудыг Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдүүд болон мэргэжлийн байгууллага, олон нийтэд сурталчлан, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-нд үүрэг болгосугай.

АРГА

С. ГҮНДЭНБАЛ

Монгол улсын Үнэт цаасны хорооны
2003 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн
14 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АЖИЛЛАХ МЭРГЭЖИЛТЭНД
АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ ЭРХ ОЛГОХ,
АТТЕСТАТЧЛАХ ТУХАЙ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

Үнэт цаасны зах зээлд оролцож, мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх иргэнээс /цаашид мэргэжилтэн гэх/ шалгалт авах, эрхийн үнэмлэх олгох, аттестатчлах үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбогдсон асуудлыг энэхүү журмаар зохижуулна.

**ХОЁР. Мэргэжилтэнд тавигдах шаардлага,
хориглох үйл ажиллагаа**

2.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжилтэн гэж үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах ажлыг эрхлэн гүйцэтгэдэг Хорооноос эрх авсан ажилтныг хэлнэ.

2.2. Мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын өмнө хүлээсэн үүргээ үнэнч шудрага, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

2.3. Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулах мэргэжилтнүүдэд дараахь шаардлага тавигдана:

2.3.1. Баклавраас доошгүй боловсролтой байх

2.3.2. Үнэт цаасны зах зээлийн талаархи суурь шалгалтанд тэнцсэн байх

2.3.3. Үнэт цаасны зах зээл дээр өөрийн хариуцсан гүйцэтгэх ажлын чиглэлээр мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн байх.

2.4. Мэргэжилтнүүд нь “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлд заасан хориглох үйл ажиллагааг мөрдөж ажиллана:

**ГУРАВ. Шалгалт зохион байгуулах,
эрх олгох**

3.1. Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулах мэргэжилтнүүдээс дараахь 2 ангилалаар шалгалт авч эрх олгоно.

1/Суурь шалгалт

Энэ шалгалтыг мэргэжлийн шалгалтанд орох хүсэлтээ ирүүлсэн бүх хүмүүс өгөх ба шалгалтын агуулга нь үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалтын талаархи ерөнхий мэдлэгийн түвшинг тогтооно.

2/Мэргэжлийн шалгалт

Мэргэжлийн шалгалтыг үнэт цаасны зах зээл дээр эрхлэх мэргэжлийн үйл ажиллагааны төрөл тус бүрээр авна. Төрөл тус бүр нь кодтой байна.

01 – брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах эрх олгох шалгалт

- 02 – Хөрөнгө оруулалтын сангийн менежрүүдэд эрх олгох шалгалт
- 03 – Хөрөнгийн бирж болон үнэт цаасны дилерүүдийн арилжааны төвийн ажилтнуудад арилжаа зохион байгуулагчийн эрх олгох шалгалт
- 04 - Үнэт цаасны клиринг - төлбөр тооцооны байгууллагын ажилтнуудад эрх олгох шалгалт
- 05 - Үнэт цаасны хадгаламжийн байгууллагын ажилтнуудад эрх олгох шалгалт
- 06 - Үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажилтнуудад эрх олгох шалгалт.
- 07 – Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалт

3.2. Үнэт цаасны зах зээл дээр андеррайтерын үүрэг гүйцэтгэх үнэт цаасны зах зээлд шууд оролцох этгээдүүд нь энэхүү журамд заасан суурь шалаглт болон мэргэжлийн шалгалтуудаас өөрийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах аль нэг шалгалтыг өгч тэнцсэн байна.

3.3. Шалгалтанд орох хүсэлт гаргасан этгээд нь өөрийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр 1 мэргэжлийн шалгалтыг зайлшгүй өгсөн байх ба шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрийн хүсэлтээр нэмэлт шалгалт өгч болно. Шалгалт өгч тэнцсэн тохиолдолд тухайн үйл ажиллагааны төрлөөр эрхийн үнэмлэх олгоно.

3.4. Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн шалгалтанд тэнцсэн этгээд Шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн Хорооны даргын тушаалаар мэргэжлийн үнэмлэх олгоно.

3.5. Мэргэжлийн шалгалтанд орж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах эрх авахыг хүссэн иргэн дараахь материалыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

- 1/ өргөдөл
- 2/ анкет
- 3/ 4*6 хэмжээний 2 хувь зураг
- 4/ үнэмлэхний үнэ төлсөн баримт
- 5/ боловсролын үнэмлэх, сертификат, гэрчилгээ болон дипломын хуулбар.

3.6. Журмын 2.3-д заасан шаардлагыг хангасан этгээдийн Хороонд ирүүлсэн баримт бичиг, хүсэлтийг үндэслэн шалгалтанд оруулж, тэнцсэн нөхцөлд үнэт зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгоно/ одоо тухайн ажилд эрхэлж буй эсэхийг үл харгалзан/

3.7. Мэргэжлийн шалгалтанд орохоор хүсэлт гаргасан этгээд нь үнэт цаасны зах зээлийг зохицуулах Монгол улсын хууль тогтоомжууд, Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржээс батлан гаргасан журам, заавруудыг сайтар судалж, үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байна.

3.8. Шалгалтын хураамжийн хэмжээг Хороо тогтооно.

3.9. Баримт бичгийн ирүүлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор өргөдөл гаргагчийн мэргэжлийн шалгалтанд оруулах эсэхийг шийдвэрлэж хариу мэдэгдэнэ. Хороо уг этгээдийг шалгалтанд оруулах боломжгүй гэж үзвэл энэ тухайгаа хариу мэдэгдэнэ.

3.10. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, эрх авсан хүмүүсийг давтан сургалтанд хамруулж аттестатчлах ажлыг Хорооны даргын шийдвэрээр байгууллагын шалгалтын комисс зохион байгуулна.

ДӨРӨВ. Шалгалтын комиссын ажиллах зарчим

4.1 Шалгалтын комисс нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын даргад Хорооны гишүүн, орлогч даргад Хорооны зах зээл зохицуулалтын хэлтсийн дарга, гишүүдэд Үнэт цаасны хорооны удирдах албан тушаалтнууд болон их, дээд сургуульд үнэт цаасны чиглэлээр хичээл заадаг эрдмийн зэрэг, цолтой багш нар тус тус орно.

4.2 Комиссын нарийн бичгийн даргын үүргийг Үнэт цаасны хорооны мэргэжлийн сургалт хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

4.3 Шалгалтын комиссын гишүүд дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд :

4.3.1 Шалгалтын тест болон асуултын нууцыг чанд хадгалах.

4.3.2 Шалгалтын асуулт, тестийг бусдаар таглуулах, хуулах үйлдэл хийсэн оролцогчдыг протоколд тэмдэглэж, шалгалтаас хасах.

4.3.3 Шалгалтын комиссын үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцох.

4.4 Шалгалтыг комиссын дарга, түүнийг эзгүйд комиссын орлогч дарга хариуцан авна.

4.5 Мэргэжлийн шалгалтын тестийг боловсруулах ажлыг Шалгалтын комисс хариуцна. Шалгалтын тестийг эцэслэн боловсруулах ажлыг Комиссын гишүүдийн саналаар итгэмжлэл олгосон 1 гишүүн хариуцан боловсруулж Комиссын хурлаар батлуулна.

4.6 Шалгалтыг суурь болон мэргэжлийн шалгалт гэсэн 2 шатлалтайгаар бичгийн хэлбэрээр тестээр болон асуултаар авч дараа нь ярилцлагад оруулна.

4.7 Тухайн тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулсан иргэн шалгалтын дараагийн шатанд орох эрхтэй болно. Тестээр авсан оноо, ярилцлагын дүнг нэгтгэн тухайн иргэнд үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх олгох, эсэх шийдвэрийг шалгалтын комисс гаргана.

4.8 Шалгалтын комиссын олонхийн шийдвээр шалгалтын дүн хүчин төгөлдөр болно.

4.9 Мэргэжлийн шалгалтын комиссын шийдвэрийг үгдэслэн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн үнэмлэхийг Хорооны дарга олгон.

4.10 Үнэмлэхийг 3 жилийн хугацаатай олгох ба уг этгээд нь эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө Хороонд хандаж аттестатчилалд хамрагдах хүсэлтээ гаргана.

4.11 Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга дараах үүрэгтэй. Үүнд:

4.11.1 Шалгалтанд орохоор хүсэлтээ ирүүлсэн хүмүүсийн материалыг энэхүү журамд нийцүүлэн хүлээн авч бүртгэх ба шалгалт авах өдрийг товлож ажлын 5 хоногийн өмнө Хорооны дарга болон шалгалтын комиссын гишүүд болон шалгалтанд орохоор хүсэлтээ ирүүлсэн иргэдэд зар хүргэнэ,

4.11.2 Шалгалт явуулах, зохион байгуулалтын асуудлыг хариуцна,

4.11.3 Шалгалтын талаарх тэмдэглэл хөтөлж, баримт бичгийг цэгцлэн Хорооны ажлын албанд шилжүүлнэ,

4.11.4 Шалгалт авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шалгалтанд тэнцсэн иргэнд эрхийн үнэмлэх олгоно,

4.11.5 Мэргэжилтнүүдэд эрх олгосон, түдгэлзүүлсэн, цуцалсан аттестатчилсан талаах дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж хавсаргана.

ТАВ. Аттестатчилах, үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1 Хороо нь 3 жил тутамд мэргэжилтнүүдийг аттестатчилалд хамруулна.

5.2 Шалгалтанд бэлтгэх сургалтыг Хороо эсвэл түүний эрх олгосноор үнэт цаасны зах зээлийн талаарх сургалт зохион байгуулах шаардлага хангасан их, дээд сургууль, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагад зохион байгуулж болно.

5.3 Аттестатчиллын өмнөх сургалт зохион байгуулах тухай зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 14 хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

5.4 Мэргэжилтнүүд аттестатчилалд орохын өмнө сургалтанд зайлшгүй хамрагдсан байхаас гадна шалгалтанд орох хүсэлтээ мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө Хороонд гаргана.

5.5 Хорооноос аттестатчилах шалгалтанд орох хүмүүсийг нэгдсэн журмаар бүртгэн авч шалгалтанд оруулан тэнцсэн тохиолдолд эрхийн үнэмлэхийн ард “АТТЕСТАТЧИЛАВ” тэмдэг дарж баталгаажуулан сунгалт хийнэ.

5.6 Хороо нь дараах тохиолдолд мэргэжилтнийг хугацаанаас нь өмнө дахин аттестатчилалд орохыг шаардаж болно.

5.6.1 түүний харьялагддаг байгууллага нь дахин шалгалтанд оруулах үндэслэл бүхий хүсэлт гаргасан,

5.6.2 мэргэжилтний үйл ажиллагаатай холбогдуулж харилцагчдаас гомдол гаргасан,

5.6.3 үнэт цаасны харилцааг зохицуулдаг хууль тогтоомжид өөрчлөлт орсон,

5.6.4 шаардлагатай бусад үндэслэлээр,

5.7 Дараах тохиолдолд мэргэжилтэнд олгосон эрхийг Хорооны даргын шийдвэрээр түр буюу бүр мөсөн цуцална.

5.7.1 мэргэжилтэн гэмт хэрэг үйлдсэн тухай шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон,

5.7.2 Үнэт цаасны зах зээлийг зохицуулах хууль тогтоомжыг зөрчсөн нь баримтаар нотлогдсон,

5.7.3 мэргэжилтэн нь Хороонд өөрийн талаар худал мэдээлэл өгсөн,

5.7.4 мэдлэг чадварын хувьд үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн шаардлага хангахгүй гэсэн дүгнэлтийг шалгалтын комисс гаргасан,

5.7.5 гэрчилгээ авсан өдрөөс хойш 12 сар үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй,

5.7.6 Хорооноос зохион байгуулсан аттестатчилах шалгалтанд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй,

5.7.7 мэргэжлийн давтан сургалтанд хамрагдаагүй,

5.8 Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлсэн, хассан тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан нийтэд зарлана.

5.9 Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлсэн мэргэжилтэн тухайн хугацаа дууссан үед, эрх нь цуцлагдсан мэргэжилтэн тухайн зөрчлийг арилгасны дараа эрхээ дахин сэргээхийг хүссэн өргөдөл гаргаж болно.

5.10 Мэргэжлийн шалгалтын комиссын хурлаар эрх цуцлах болон сэргээх тухай асуудлыг хэлэлцэж, гаргасан шийдвэрийг үндэслэн Хорооны даргын тушаалаар эрх сэргээнэ.

5.11 Мэргэжилтэн Хорооноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ҮНЭМЛЭХ

----- овогтой -----

Үнэт цаасны хорооны мэргэжлийн шалгалтын комиссын 200. оны ... сарын ..-ний өдрийн ... тоот шийдвэрийг үндэслэн Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр ажил, үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх олгов.

Үнэт цаасны хорооны дарга -----

Ажил үйлчилгээний чиглэл -----

Хүчинтэй хугацаа -----

Сунгалт -----